

ХИЛИЙН БООМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА

STUDY OF THE ECONOMIC IMPACT OF BORDER PORT ACTIVITIES



ХИЛ СУДЛАЛ

Г.Галбадрах

Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн захирал, докторант

Galbadrakh.G

Ph.D candidate, Director at the School of Border Service, University of Internal Affairs, Mongolia

*Хариуцлагатай зохиогч: Email хаяг: galbadrakh.gan@uia.gov.mn

Хураангуй: Монгол Улсын Хил хамгаалах байгууллага хилийн аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүргээ хил залгаа улсуудтай харилцан итгэлцэл, хамтын ажиллагаанд тулгуурласан энхийг сахих, энх тайванч байдлаар зэрэгцэн орших зарчмыг хүндэтгэн хэрэгжүүлэх чиглэлийг «Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого»-оор тодорхойлсон бөгөөд үйл ажиллагаандаа олон улсын хэмжээнд тавигдаж буй бүхий л шаардлагыг хангах хэрэгцээг бий болгож байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхээр тусгасан. Шинэ сэргэлтийн бодлогын онцлог нь бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгаж, төр болон хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн санаачилга, ур чадвар, туршлагыг Монгол Улсын хөгжлийн цөм хэмээн үзэж буй явдал юм. Шинэ сэргэлтийн бодлогын 6 хүчин зүйлийн нэг болох Боомтын сэргэлтийн бодлогын үндсэн зорилго нь боомтоор дамжин хийгдэх худалдааг дэмжих, хөнгөвчлөх, бизнес эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгжүүдийн ашиг орлогыг нэмэгдүүлэхэд чиглэж байгаа. Мөн олон улсын худалдааны нэвтрүүлэлт, түгээлт, тээвэр зохицуулалт, логистикын талаарх дотоодын дүрэм журам, стандартыг зохицуулах шаардлага урган гарч байна.

Энэхүү ажлаар хилийн боомтоор нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо, гадаад худалдааны орлого, экспорт, импортын бүтээгдэхүүний хэмжээг сүүлийн 10 жилийн статистик мэдээлэлд үндэслэн хамаарлыг тогтоох корреляц, регрессийн шинжилгээ хийж, хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэхэд эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлж болохыг тодорхойлов.

Abstract: This paper the Mongolian Border Guard has defined the direction of implementing its special function of ensuring border security by respecting the principles of peacekeeping and peaceful coexistence based on mutual trust and cooperation with neighboring countries in the “Policy of the Mongolian State on Borders”, and it creates the need to meet all international requirements in its activities.

In this work, correlation and regression analysis were conducted to determine the relationship between the number of vehicles entering the border crossing, foreign trade income, and the volume of exports and imports based on statistical data from the last 10 years, and it was studied that increasing the number of vehicles entering the border crossing positively affects economic growth.

Түлхүүр үг: Хил судлалын онол, арга зүй, хилийн боомтын үйл ажиллагаа, эдийн засаг, дотоодын нийт бүтээгдэхүүн, экспорт, импорт

Key words: Border studies theory and methodology, border operations, economics, gross domestic product, exports, imports



Удиртгал

Хилийн	боомтын	үйл
--------	---------	-----

ажиллагааны онолын үндэслэл

Хилийн боомт (Х.Асхар, 2020) гэдгийг Монгол Улсын хилийн шугамын дагуух хил орчмын нутаг дэвсгэрт, зам харилцаанд тулгуурлан байрлаж, тусгайлан тоноглож, төхөөрөмжилсөн газар, хуулиар олгогдсон эрх бүхийн байгууллагууд улсын хил нэвтрэх, зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа бараанд хяналт шалгалт хийх зорилготой газар гэж тодорхойлдог байна.

Хилийн боомтын үйл ажиллагаа, шалган нэвтрүүлэх албаны онол, арга зүй нь хил судлалын ерөнхий онолоос гадна төрийн хилийн бодлогын онол, гаалийн онол, хилийн хяналт шалгалтын онол, хил хамгаалах урлагийн онол, хилийн стратеги, оперативын онол, хилийн цэргийн тактикийн онол зэрэг хэсгийн онолууд (тусгай онолууд)-аас бүрддэг.

Хил судлалын шинжлэх ухаан нь өргөн хүрээтэй мэдлэгийн салбар бөгөөд орчин цагийн шинжлэх ухааны судалгааны түгээмэл аргуудыг ашигладаг. Тухайлбал, цэргийн шинжлэх ухаан, нийгмийн шинжлэх ухаан, техникийн шинжлэх ухаан, байгалийн шинжлэх ухааны хүрээнд боловсруулагдсан аргуудыг ашигладаг бөгөөд эдгээр нь арга зүйн (методика) болон арга судлалын (методология) үндсийг нь бүрдүүлж байна. Өнөөдөр синергетикийн болон системийн онолуудыг дангаар болон хамтатган хэрэглэж байна. Эдгээр аргаас синергетик арга нь хилийн орчны судалгаанд бүрэн тохирно гэж үздэг (Ц.Ганболд, 2022).

Хил судлал нь цэрэг, техникийн ухаан, эдийн засаг, улс төр судлал, эрх зүй зэрэг шинжлэх ухааны мэдлэгийн уулзвар дээр оршиж, цогц, нэгдмэл чанарыг илэрхийлж байдаг. Үүнээс үзвэл улсын хил хамгаалалтын онол нь хил судлалын ухааны гол цөмийг бүрдүүлж байна гэж үзэх үндэслэлтэй ба хил судлалын шинжлэх ухаан олон шинжлэх ухааны цогц байдгийн мөн чанар нь тэдгээр шинжлэх ухааныг улсын хил, түүний хамгаалалт гэсэн нэг цэг дээр төвлөрүүлж тэдний уялдаа холбоог хангаж байдагт оршино (Ц.Ганболд, 2022) гэж үзжээ.

Монгол Улсын хилийн урт 8252.6 км бөгөөд үүнээс ОХУ-тай 3543 км, БНХАУ-тай

4709.658 км урт хилээр хиллэдэг (Монгол Улсын хил, 2019).

Монгол Улсад нийт 39 боомт байдгаас (Ц.Ганболд, 2022) Монгол Улс, БНХАУ-тай олон улсын зорчигч, ачаа тээврийн харилцааны зориулалттай байнгын ажиллагаатай Булган, Замын-Үүд төмөр зам, авто зам, Бичигт, Сүмбэр, хоёр талын зориулалттай байнгын ажиллагаатай Шивээхүрэн, Гашуунсухайт, түр буюу улирлын ажиллагаатай Даян, Байтаг, Бургастай, Ханги, Баянхошуу, Хавирга зэрэг 17 боомт үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол Оросын хилийн 16 боомтоос олон улсын зорчигч, тээврийн харилцааны Сүхбаатар-Наушки, Цагааннуур-Ташанта, Алтанбулаг-Хиагт, Эрэнцав-Соловьевск (авто замын), Боршоо-Хандгайт, хоёр талын зорчигч, ачаа тээврийн харилцааны Эрэнцав-Соловьевск (төмөр замын), Ханх-Монд, Ульхан-Дээд Ульхан, Арцсуурь-Цагаан толгой, Тэс-Шарсуурь гэсэн 10 боомт байнгын үйл ажиллагаа явуулж байна. бусад 19 боомт нь Монголын эсвэл Оросын талын хилийн боомтын дэд бүтэц хөгжөөгүй, хилийн хяналт шалгалтын байгууллагын албан хаагчид ажиллах, амьдрах нөхцөл бүрдээгүйн улмаас ажиллахгүй байна.

Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн тоог Үндэсний статистикийн хорооноос сүүлийн 10 жилийн байдлаар гаргасан судалгаанаас үзэхэд 2024 онд Монгол Улсын хилийн боомтуудаар нийт 7179.2 (давхардсан тоогоор) мянган зорчигч нэвтэрснийг өмнөх онуудтай харьцуулахад, 2019 оноос 17.8 хувиар, 2020 оноос 5.3 дахин, 2021 оноос 11.1 дахин, 2022 оноос 3.6 дахин, 2023 оноос 34.6 хувиар тус тус өсжээ. 2020-2021 онд дэлхий дахинд КОВИД-19 цар тахал дэгдсэнтэй холбоотойгоор Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын тоо огцом буурсан боловч 2022 оны 2 дугаар сараас эхлэн хилийн боомтуудыг үе шаттайгаар нээж эхэлснээр зорчигчдын тоо аажмаар нэмэгдэж эхэлжээ. Мөн манай улсын хилээр 2024 онд давхардсан тоогоор 4 030.5 мянган тээврийн хэрэгсэл нэвтрүүлсэн нь 2015 онтой харьцуулахад 2.2 дахин, 2019 оноос 49.6



МОНГОЛ УЛСЫН ХИЛ



МОНГОЛЫН СТАТИСТИК АГЕНС

хувиар, 2023 оноос 35.2 хувиар өссөн байна. /Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо/

Хөрш орнуудын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн статистик мэдээнээс үзэхэд 2024 онд ОХУ-ын авто замын болон төмөр замын боомтоор эхний 10 сард ОХУ-Хятад, Монголын хилийн боомтуудаар 482,000 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 54.3%-иар ихэссэн. Төмөр замын боомтоор нэвтэрсэн экспортын ачаа тээвэрлэлт өмнөх оны мөн үеэс ойролцоогоор 20-22% өсөлттэй байжээ.

БНХАУ-ын авто замын боомтуудаар 2024 онд нийт 1.77 сая тээврийн хэрэгсэл нэвтэрсэн бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 48.8% өссөн байна. Хилээр нэвтэрсэн нийт зорчигчдын тоо 610 саяд хүрсэн нь 2023 онтой харьцуулахад 43.9%-иар өссөн үзүүлэлт юм.

Хилийн боомтын үйл ажиллагаа нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилтэй салшгүй холбоотой. Үүнийг дараах үр дүнгээр харуулья.

Материал, арга зүй

1. Корреляцийн шинжилгээний үр дүн

Үзүүлэлт	Нийт хил нэвтэрсэн тээврийн хэрэгсэл	Гадаад худалдааны нийт эргэлт, сая ам \$	Нийт төвлөрүүлсэн импорт, экспортын татвар, сая. төг	ДНБ, тэрбум төг
Нийт хил нэвтэрсэн тээврийн хэрэгсэл	1			
Гадаад худалдааны нийт эргэлт, сая ам \$	0.661874568	1		
Нийт төвлөрүүлсэн импорт, экспортын татвар, сая. төг	0.663040674	0.996412781	1	
ДНБ, тэрбум төг	0.671915447	0.991208195	0.99120214	1

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо гадаад худалдааны нийт эргэлт, нийт төвлөрүүлсэн экспорт, импортын татварын орлого ба ДНБ-ний өсөлтөд нөлөөлж буй нөлөөллийг хамаарлын шинжилгээгээр тодорхойлоход коэффициент 0.66-0.67 буюу хүчтэй бөгөөд эерэг хамааралтай байна. Эндээс гадаад

Судалгаанд 2015-2024 онд Замын-Үүд хилийн боомтоор нэвтэрсэн тээврийн хэрэгслийн мэдээллийг гаалийн цахим үйлчилгээний системээс, Монгол Улсын эдийн засгийн 2015-2024 оны үзүүлэлтүүдийг Үндэсний статистикийн хорооны албан ёсны хуудаснаас авсан. Судалгаанд статистик боловсруулалтын Data analyses программыг ашиглав.

Шинжилгээ ба үр дүн

Хилийн боомтын нэвтрүүлэх чадвар, үйлчилгээний чанар нэмэгдсэнээр гадаад худалдаа тэлж улмаар Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд нөлөөлдөг. Монгол Улсын экспортын голлох бүтээгдэхүүн нь уул уурхайн бүтээгдэхүүн бөгөөд БНХАУ дангаар худалдан авч байна. Энэ нь нэг талаас нэг улсаас хараат байдлын аюулыг бий болгож байна. Хилийн боомтын нэвтрүүлэлт Монгол Улсын эдийн засагт гадаад худалдааны тэнцэл ашигтай байх, төсвийн татварын орлого бүрдүүлэлт болон эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлдөг болохыг дараах шинжилгээгээр тодорхойлъё.

худалдааны нийт эргэлт, нийт төсөвт төвлөрүүлсэн гадаад худалдааны татварын орлого нь дотоодын нийт бүтээгдэхүүнийг бүрдүүлдэг тул цаашид дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд хилийн боомтын нэвтрүүлэлтийн хурд хэрхэн нэмэгдүүлэхийг регрессийн шинжилгээгээр тодорхойлъё.

2. Регрессийн шинжилгээний үр дүн

Regression Statistics	
Multiple R	0.6719
R Square	0.4514
Adjusted R Square	0.3829
Error	15257.8
Observations	10

ANOVA					
	df	SS	MS	F	Significance F
Regression	1	1532868516	1.53	6.584445	0.033333
Residual	8	1862411943	2.33		
Total	9	3395280459			

	Coefficients	Standard Error	t Stat	P-value	Lower 95%	Upper 95%	Lower 95.0%	Upper 95.0%
Intercept	-1158.6	17892	0.06476	0.9499	42417.7	40100.39	42417	40100.39
X Variable	0.0353	0.0137	2.566	0.033	0.00357	0.0670	0.0035	0.067035

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо(х) ДНБ-ний өсөлт(у)-ийн нөлөөллийн регрессийн шинжилгээний үр дүнд детерминацийн коэффициент 0.45 буюу ДНБ-ний өсөлтөд хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо 45 хувиар нөлөөлөх хүчин зүйл бөгөөд ДНБ-ний бусад бүрэлдэхүүн аж ахуйн нэгж, өрх гэр, төрийн хэрэглээний нөлөөлөл нь 55 хувь байна. Хамаарлын коэффициент итгэлтэй гарсан ба нөлөөлөл нь 0.0353 буюу тээврийн хэрэгслийн нэвтрэлт тутамд ДНБ 3.53 сая төгрөгөөр нэмэгдэх зүй тогтолтой байна. Иймд хилийн боомтын дэд бүтэц, хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмжийн хүчин чадал, хүний нөөц, алба хаагчдын чадавхийг нэмэгдүүлж чадвал ДНБ-ний өсөлтийг шууд нэмэгдүүлэх хүчин зүйл болох нь энэхүү судалгааны үр дүн харуулж байна.

Дэлхий дахинд болж буй хүн амын өсөлт, зорчигчдын урьд өмнө байгаагүй чиг хандлага, шилжилт хөдөлгөөний жигд бус хэв маяг, геополитик болон гео-эдийн засгийн нарийн төвөгтэй байдал, терроризмын аюул занал нэмэгдэж байгаа нь хилийн хяналт шалгалт, зорчигчдын аюулгүй байдал нь байнга тулгамдсан

асуудлын нэг болгосон байна. "Smart-Ухаалаг" хилийн хяналтын системийг технологийн тусламжтайгаар боловсронгуй байдлаар хэрэгжүүлэх нь улсын хилээр нэвтрүүлэх зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа бараа бүтээгдэхүүнийг улсын хилээр аюулгүй, илүү хялбар нэвтрүүлэх орчныг бий болгох түлхүүр гэж үздэг.

Харин ирээдүйд яах бол, ямар өөрчлөлт, шинэчлэлт хүлээж байна? гэх асуултад хариулт өгөхийг оролдлоо. Мэдээллийн техник, технологийн эрин зуунд нэлээдгүй зүйлд өөрчлөгдөн буйг харж, мэдэрч байна.

Өндөр технологийн одоогийн болон шинээр гарч ирж буй чиг хандлага

Хилийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг бөгөөд дэлхийн улс орнуудын амин чухал асуудал юм.

Хилийн аюулгүй байдалд:

-терроризм,

-хууль бус цагаачлал,

-хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус наймаа зэрэг асуудал нь өөрөө сорилтуудыг бий болгож, энэ чиглэлээр тэдгээрийг илрүүлэх олон



МОНГОЛЫН
Дотоод
Хэрэг
Яам



ХИЛ СУДЛАЛ

төрлийн технологиудыг бий болгосон. Энэ нь хил зөрчигчдийг хууль бусаар нэвтрүүлэх, хилийн боомтоор аюултай эд зүйлсийг хууль бусаар нэвтрүүлэх явдлыг бууруулж байна.

Гэвч хүний нүүр царай таних биометрийн дэвшилтэт программ хангамжийг ашиглах явдал улам бүр нэмэгдэх энэ цаг мөчид хүний эрхтэй холбоотой асуудлаар шүүмжлэлд өртөх сөрөг үр дагавартайг анхаарах ёстой.

Эдгээр өндөр технологид суурилсан улсын хил хамгаалалтын системүүд аюулгүй байдлын хяналтын хурд, хамрах хүрээг сайжруулах амлалтаа биелүүлэхийн тулд засгийн газрын зардлын албаны хүмүүс болон бусад бодлого боловсруулагчид анхааралтай ажиглах болно.

Хилийн аюулгүй байдлыг хангахад технологи хэрхэн нөлөөлөх вэ?

Хилийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд техник технологийн хэрэглээ нэмэгдэж байгаа энэ үед Хил хамгаалах байгууллагын алба хаагчид орчин үеийн дүрслэл, таних төхөөрөмжийг ашиглах ёстой болсон. Тэд мөн харилцан уялдаатай мэдрэгчид суурилсан технологиос илрүүлэх өгөгдөл мэдээлэл дээр ажиллах, түүнийг ашиглах ур чадвартай байх шаардлага үүсэж байна.

Мөн түүнчлэн харилцан ажиллагаатай байгууллагуудтай хамтран мэдээлэл солилцож, үйл ажиллагаагаа тодорхой болгох, болзошгүй хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан хилийн зөрчлийг шийдвэрлэх, олон нийтэд ухуулан таниулах зэрэг үр дүнтэй харилцан ажиллах шаардлагатай байна. Технологийг дагаад нэгдсэн нэг систем платформ дээр мэдээллээ солилцох шаардлага үүсэж байна.

Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник технологи, хиймэл оюун ухааныг ашиглах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх олон улсын чиг хандлага

Дэвшилтэт техник технологийг нэвтрүүлснээр хилийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд шинээр нэмэгдэх ур чадваруудын асуудлыг улам боловсронгуй

болгож байна. Жишээлбэл, Сүүлийн үеийн агаарын замын хилийн боомтуудад мэдрэгч системд тулгуурласан тоног төхөөрөмжийг суурилуулж, тоноглох болсон. Эдгээр нь хиймэл оюун ухааны технологийг ашиглаж хоорондоо нэг систем болон холбогдох бөгөөд хүний царай таних технологиор тоноглогдсон камеруудаас цуглуулсан мэдээлэл нь тэсрэх бөмбөг хууль бусаар хил давуулсан этгээд байж болзошгүй мэдээлэлтэй холбогдож өгдөг. Энэ холбоо нь хяналт шалгалтын олон цэгүүдэд хөндлөнгөөс хяналт тавих, оролцоог бий болгох боломжийг олгож, агаарын хөлөгт суухаас өмнө ойрхон байгаа хилийн боомтын аюулгүй байдлыг хангуулах ажилтнуудад түүний байршлыг мэдэгдэх боломжтой.

Хилийн боомтод хилийн хяналт шалгалт, аюулгүй байдлыг хангуулахад хиймэл оюун ухааны технологийг дараах байдлаар ашиглахаар байна. Үүнд:

-зорчигчийн сэтгэл хөдлөлийг илрүүлэх

-магадлалыг тооцох аргачлал зэрэг алгоритм багтаж байна.

Хилийн боомтод ашиглаж буй дэвшилтэд техник технологийг дөрвөн төрөлд ангилан авч үзэж байна.

-Хаалт, хашаа, дохиолол, хяналтын техник технологи;

-Хууль бус, хориглосон болон хязгаарласан ачаа, барааг илрүүлэх техник технологи;

-Алслагдсан бүсийн хилийн боомтод ажиллах хилийн хяналт шалгалтыг хянах орон зайн хяналтын технологи;

-Биометрийн таних технологи зэрэг болно.

Хаалт, хашаа, дохиолол, хяналтын техник технологи:

Давуу тал: Хилийн боомтод хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах, боомтын аюулгүй байдлыг хангахад

Сул талууд: нураах, амархан эвдрэх, барилга, засвар үйлчилгээний зам, хил зөрчигчид хаалт, хашааг давах зэргээр дамжин хил давж болно.

Ачаа бараанд үзлэг шалгалт хийх /сканнерууд X-Ray/



Ихэнх хууль бусаар нэвтрүүлж буй мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хилийн боомтоор нэвтрүүлж, гол төлөв хууль ёсоор нэвтрүүлж буй бараа бүтээгдэхүүнтэй холих, тээврийн хэрэгсэлд нуух зэрэг арга залиг хэрэглэж байна.

Хилийн боомтод хууль бус, хориглосон болон хязгаарласан ачаа, барааг тээврийн хэрэгсэл, чингэлэг, илгээмжээс ялгаруулж буй агаарын даралт, хийн өөрчлөлт зэрэг шинж тэмдгүүдэд тулгуурлан мэдрэгчтэй техник хэрэгслийг ашиглан илрүүлж байна.

Ингэснээр хамгийн сүүлийн үеийн рентген болон гамма сканнер нь хууль бус барааг илрүүлэхэд маш үр дүнтэй байгааг онцолж байна. Харин эдгээр сканнерууд нь үнэтэй байх учир тэдгээрийг үр дүнтэй ашиглахын тулд хилийн хяналтын байгууллагуудын алба хаагчдад маш өргөн хүрээний сургалт явуулах шаардлага үүсдэг байна. Энэхүү тоног төхөөрөмж нь өөрөө овор ихтэй тул гарц бүрт суурилуулснаар тээврийн хэрэгслийн эгнээний тоог хоёр дахин бууруулж болно.

Алслагдсан бүсийн хилийн боомтод ажиллах хилийн хяналт шалгалтыг хянах орон зайн хяналтын технологи

Алслагдсан бүс нутгуудад байрлалтай хилийн боомтоор хил нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийх, үйл ажиллагаанд хяналт тавихын тулд олон төрлийн програм хангамжийг нэгтгэсэн цахим хяналтын технологийг ашиглах явдал юм.

Сүүлийн жилүүдэд нисгэгчгүй нисэх хэрэгсэл /төхөөрөмж/, нисэх онгоцуудыг хилийн хэсэгт илүү их ашиглах болсон байна. Эдгээр техник хэрэгслүүдийн тусламжтайгаар харьцангуй бага зардлаар их хэсгийг хурдан бөгөөд үр ашигтайгаар хянах боломжтой. Харин хязгаарлагдмал тэжээлийн ашиглалт, үүнийг дагасан ашиглалтын хугацаа зэргээс хамаараад түүний сул талууд гарч байна.

Биометрийн таних технологи

Сүүлийн үеийн технологийн дэвшлийн үр дүнд улсын хилээр нэвтрэх буй сэжигтэй зорчигч /хил зорчигч/-ийг танихын тулд түүний физик шинж чанарыг ашиглан хяналт шалгалтыг явуулах олон

төрлийн биометрийн таних технологүүд бий болсон. Ийм технологид суулгагдсан RFID чип дээр биометрийн өгөгдөл агуулсан цахим паспортууд орно. Мөн түүнчлэн хиймэл оюун ухаанд суурилсан хүний нүүр, царай таних программыг ашиглан хурууны хээ уншигч, нүдний солонгон бүрхэвч зэрэг дахин давтагдашгүй шинж байдлыг шалгах камер ашигладаг. Энэхүү технологи нь найдвартай, нарийвчлалтай, шуурхай байдлыг хангах үүднээс шалгагч, улсын байцаагч нартай шууд харьцдаггүйгээрээ давуу талтай.

Харин биометрийн өгөгдэхүүн мэдээллийн нууцлал, мэдээллийн аюулгүй байдалд эрсдэлтэй гэж үздэг. Хилийн боомтод ажиллаж буй хилийн хяналтын байгууллагуудын ажилтнууд тэдгээрийг үр дүнтэй ашиглахын тулд мөн адил өргөн хүрээний сургалтыг явуулахыг шаарддаг бөгөөд хүний эрхийг хөндсөн зарим асуудал гарах өндөр эрсдэлтэй. Энэ нь ялангуяа өнгөт арьстай хүмүүсд илүү ихээр өртөх магадлал өндөр байдаг.

Аюулгүй байдлын технологийн шинэчлэл

Хилийн аюулгүй байдлыг хангахад "ухаалаг" эсвэл "виртуал" зэрэг технологийн дэвшил рүү шилжсэн.

Нүүр царай таних системийг хурдацтай хөгжүүлэх

Хилийн боомтод хамгийн амжилттай нэвтрүүлэх технологийг тодорхойлоход хэцүү ч дэлхийн улс орнууд хүний нүүр царай таних технологийн хэрэглээг эрчимтэй өргөжүүлж байгааг судалгааны байгууллагууд болон олон улсын шинжээчид үзэж байна.

Дэвшилтэт техник технологийн ирээдүй

Өнөөдөр янз бүрийн технологийн стартапууд болон засгийн газрын агентлагууд хиймэл оюун ухаанаар ажилладаг нисгэгчгүй нисэх хэрэгсэл /дрон/-үүдийг бүтээж байгаа бөгөөд энэ нь хүний оролцоог багасган хиймэл оюун ухаанд суурилсан технологийг илүү нэвтрүүлэхийг эрмэлзэж байна. Тухайлбал, Европын холбооноос санхүүжүүлдэг AirSens төсөл нь сүлжээнд холбогдсон



ХУУЛЬ САХИУЛАХУЙ

нисгэгчгүй агаарын тээврийн хэрэгслийн тагнуулын болон өгөгдөл боловсруулах алгоритмуудыг боловсруулсан. Улсын хилийг хамгаалах болон бусад хууль сахиулах байгууллагууд тэднийг урьдчилан тогтоосон хилийн бүсэд байрлуулж, хүний оролцоогүйгээр газар дээрх хүмүүсийг сканнердаж, хянах боломжтой.

Төсөөлөл ямар байх вэ?

2060 онд хил хязгаар нь маш хүчирхэг мэдрэгч бүхий олон мянган жижиг бие даасан дронудын чимээгүй эргэлддэг давхарга болно гэж төсөөлж болно. Нүүр царай таних чадварыг хиймэл оюун ухаан, том өгөгдлийн шинжилгээтэй хослуулсан мэдээллийн технологи илүү нэвтэрнэ гэж үзэж байна.

Дүгнэлт

Хилийн боомтын үйл ажиллагааг эрчимжүүлэх нь Монгол Улсын эдийн засагт эерэгээр нөлөөлдөг болохыг корреляц, регрессийн шинжилгээгээр баталсан.

Монгол Улсын Засгийн Газраас “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд авч хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний дагуу “Боомтын сэргэлт”-ийн бодлогыг уялдуулж, тогтмол ажиллагаатай хилийн боомтын тоог нэмэгдүүлэх, ачаа, тээвэр, зорчигчийн нэвтрүүлэх орц, гарцыг нэмэгдүүлэх олон ажил хийгдэж байна. Энэ нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлөх боловч, зарим эрсдлийг тооцох шаардлагатай. Үүнд:

1. Байнгын ажиллагаатай хилийн боомтыг нэмэгдүүлснээр ачаа, тээврийн эргэлт нэмэгдэх боловч, хүний нөөцийн хомсдол үүсэх магадлалтай;

2. Хилийн боомтын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэн төхөөрөмжлөхөд улсын төсвөөс их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай;

3. Хилийн боомт дахь хилийн хяналт шалгалтын чадамж сулрах эрсдэлтэй байна.

Дээрх эрсдлийг тооцож, хилийн боомтын үйл ажиллагааг сайжруулснаар Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод чиглэгдсэн хөтөлбөр, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжих боломжтой гэж дүгнэлээ.

Мөн түүнчлэн илтгэлийн төгсгөлд олон улсын чиг хандлага, техник технологийн дэвшлийн талаар судлан оруулж, Монгол Улсын хилийн боомтуудад цаг тухайд нь нэвтрүүлж байх шаардлага байгааг харуулахыг зорисон болно.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

- Abbass, I. M. (2016). MANAGEMENT SKILLS – TOOLS FOR LEADERSHIP IMPERATIVES IN DEMOCRACY. *European Scientific Journal*, July edition vol. 8, No.16.
- Aithal, P. S. (2019). A MODERN LEADERSHIP THEORY BASED ON ATTITUDE-BEHAVIOUR (AB) FRAMEWORK. *Research in Higher Education, Learning and Administration*, 62-65.
- bayas, T. (2021). Satisfaction ... *Inter Jor mjbvbskduc*, 359-342.
- Bennis, W. G. (2008,2021). Leadership is the capacity to translate vision into reality. *Journal of Property Management*, vol. 73, no. 5.
- Cotter-Lockard, D. (2009). *Edgar Schein's Organizational Culture and Leadership, as seen through the lens of*. ResearchGate.
- Dalakoura, A. (2010). *Differentiating leader and leadership development : A collective framework for leadership development*. . *Journal of Management Development*.
- Donate, M. G. (2011). Organizational factors to support knowledge management and innovation. . *Journal of Knowledge Management*, 15(6): 890–914.
- McFarlane. (2008). Effectively managing the 21st century knowledge worker. *Journal of Knowledge Management Practice*, 9(1):3-7.
- Millar, C. (2016). Knowledge intensive organisations: on the frontiers of knowledge management. . *Journal of Knowledge Management*, 20(5): 845–857.
- Nataša Ritonija, N. L. (2016). PROFESSIONAL SKILLS IN MANAGEMENT AND LEADERSHIP, ENTREPRENEURSHIP AND

COMMUNICATION-THE E-PROFMAN PROJECT. *ReasearchGate*, 1-5.

Seidle, B. F. (2016). *Do leadership training and development make a difference in the public sector?* . Public administration review.

Монгол Улсын хил. (2019). *Монгол Улсын хил*. Retrieved from Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Хил хамгаалах ерөнхий газар: <https://bpo.gov.mn/content/54>

Х.Асхар. (2020). Хилийн боомтын үйл ажиллагааг боловсронгуй болгох арга зам. In Х.Асхар, *Хилийн боомтын өнөөгийн байдал* (р. 4). Улаанбаатар.

Ц.Ганболд, Д. (2022). *Хил судлал*. Мөнхий үсэг ХХК.



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОХИРУУЛАГЧ
АГЕНТЛАГ
ХИЛ
ХАМГААЛАХ
ЕРӨНХИЙ
ГАЗАР